

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, байгаль орчин), Гэрэлмаа Энхболор

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийг хийх, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах, нэгдсэн бодлогыг тодорхойлох;							
1	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулна.	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг батлуулсан.	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. /1 төлөвлөлтийн баримт бичиг/	Уг төлөвлөлтийн баримт бичгийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан судалгаа, шинжилгээнд тулгуурлан, зорилго, зорилт нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь зорилгодоо нийцсэн, төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байдлаар бүх талын оролцоог хангаж, нийт 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран боловсрууллаа. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулахдаа нийт 14 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, Шинжлэх	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

57

				<p>ухааны академийн Бага болон Их чуулганаар хэлэлцүүлсэн нь шинжлэх ухаанд суурилсан бодлого боловсруулахад онцгой ач холбогдолтой болсон. Олон нийтийн хэлэлцүүлэгт шүүх засаглалын байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллага, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагчид, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцож, нийт 644 санал гаргаснаас хуульд тогтоомжийн дагуу үндсэн чиглэлийн төсөлд тусгасан болно.</p> <p>"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төсөл нь "Шинэ итгэл-Эрс шинэчлэл"-д зорин "Хүний хөгжил", "Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл", "Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил", "Байгаль орчин, ногоон эдийн засаг", "Төрийн бүтээмж, засаглал", "Бүсийн хөгжил", "Үндэсний өрсөлдөх чадвар", "Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун" гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд Үндэсний,</p>		
--	--	--	--	---	--	--

					Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, Хөтөлбөрийн гэсэн 4 түвшний үр дүнг, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлсон. Дээрх үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулж тодорхойлсон нь олон улсад хүлээсэн манай улсын үүрэг амлалтыг биелүүлэх, нөгөө талаас уг баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чухал алхам боллоо.		
2	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулна.	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г батлуулсан.		Уг төлөвлөгөө нь "Хүн төвтэй" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох"-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн дөрвөн бодлогын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

				<p>тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, нийтдээ 18.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх юм. Эдийн засгийн эрх чөлөөний реформын хүрээнд бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, татварын орчны шинэчлэлийг хийж, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулалтыг хязгаарласан, хаасан зохицуулалтыг багасгах, ялгамжтай байдлыг арилгана. Төсвийн зардлын реформын хүрээнд төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, процессын дахин инженерчлэлийг хийж, төрийн үйлчилгээг хялбар, хүн төвтэй, про-актив хандлагаар эрчимжүүлнэ. Төрийн албаны реформын хүрээнд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ. Үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн</p>		
--	--	--	--	---	--	--

					<p>засаглалын реформын хүрээнд төрийн өмчит компаниудын реформыг эрчимжүүлж, бүтээмжийг сайжруулж, зардлыг бууруулж, тэдгээрийн хөрөнгийн удирдлагыг сайжруулна. Баялгийн санг арвижуулж, геологи, хайгуул, болон ашиглалтын түвшнийг нэмэгдүүлэх, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц арга хэмжээг хэрэгжүүлж, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" нь үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчимд суурилсан, урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй бүрэн уялдсан төлөвлөлтийн баримт бичиг болсон юм.</p>		
3	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгнө.</p>	<p>Арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байх, хувиар</p>	-	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.</p>	<p>"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар батлуулсан бөгөөд Монгол Улсын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл нь "Хүн төвтэй" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "Эдийн засгийн эрх чөлөөг</p>	<p>1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	100%

					<p>цогцлоох"-ыг зорьж, энэ хүрээнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Мөн "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлууллаа. "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төсөл нь "Шинэ итгэл-Эрс шинэчлэл"-д зорин "Хүний хөгжил", "Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл", "Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил", "Байгаль орчин, ногоон эдийн засаг", "Төрийн бүтээмж, засаглал", "Бүсийн хөгжил", "Үндэсний өрсөлдөх чадвар", "Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун" гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд Үндэсний, Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн,</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>Хөтөлбөрийн гэсэн 4 түвшний үр дүнг, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлсон. Түүнчлэн, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/13 тушаалаар “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ыг баталсан бөгөөд түүнийг танилцуулах 2 удаагийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн төлөвлөлтөд оролцож буй албан хаагчдад зохион байгуулж, уялдааг хангаж, арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа. Нийт 480 оролцогчид хамрагдсан. “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулах аргачлалын дагуу Ховд, Өмнөговь, Булган аймгуудыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд санал, зөвлөмж өгч ажиллалаа.</p>		
4	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар судалж, боловсруулна.	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судлах, хувиар	-	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалсан байна. /100 хувь/	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад бүс, орон нутгийн онцлогт нийцүүлсэн, салбар болон салбар хоорондын	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай зэрэг өөрчлөлтүүдийн талаар нарийвчилсан тооцоо, судалгаа хийх зайлшгүй шаардлага бий болсон. Дээрх цогц судалгааны ажлын хүрээнд: -Монгол Улсын дунд хугацааны бодлого, төлөвлөлт, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг тоон утгаар чанаржуулах цогц судалгаа хийхийн тулд олон төрлийн өгөгдлүүд, загвар ашиглах; -Уялдаа холбоотой системүүдийн хөгжлийг загварчлах, орон нутаг болон салбар хоорондын харилцан үйлчлэлийг харах зорилгоор Системийн динамик (System Dynamics) загвар ашиглах; -Орон нутаг, салбар хоорондын өөрчлөлтүүдийн нөлөөг тооцоолох Динамик симуляц ашиглах зэрэг хөгжлийн загваруудыг хөгжүүлэх юм.</p>		
5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллийг эргэлтэд оруулна.	Хэрэгжилтийн явц, хувиар	Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудлыг судлах	Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудлыг судалсан байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “ Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө.” гэж заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах Ажлын хэсгийг байгуулж байна. Тус Ажлын хэсэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан, Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах үйл явцыг удирдан зохион байгуулах, холбогдох байгууллагуудын мэдээллийн урсгалын нэгтгэл, харилцан уялдааг сайжруулах, мэдээллийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх үүрэгтэй болно. Энэхүү ажлын хэсэг нь төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөө нь 2028 онд бүрэн хэрэгжиж дуусна.		
6	Монгол Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн	Монгол Улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх, хувиар	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”, 27 дугаар зүйлийн	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө.		Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2024 онд зөвшөөрөл өгсөн.	нягтлан шалгаж, зөвшөөрөл өгсөн байна. /100 хувь/	27.1.8-т "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх" гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т "улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх; гэсэн шаардлагыг ханган боловсруулж төлөвлөлт, төсөвлөлтийг уялдуулж ажилласан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.3-т заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамнаас улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгөхөд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ болон төсвийн төслийн уялдааны нийцэл 2022 онд 36.1 хувь, 2023 онд 47.1 хувь, 2024 онд 71.0 хувь, 2025 онд 92.0 хувь болж нэмэгдсэн байна.		
7	Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз	Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байх, хувиар	-	Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байна. /100 хувь/	Монгол Улсын Үндсэн хуулийн 5.1 дэх хэсэгт "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна." хэмээн заасан байдаг. Монгол Улсын нийт эдийн засгийн 93.0	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

<p>суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.</p>				<p>хувийг уул уурхайн салбар бүрдүүлдэг. Уул уурхай дотроо нүүрс дангаараа 60.0 хувийг эзэлж байгаа ба уул уурхайн салбараас хэт хамааралтай тул дэлхийн зах зээлийн түүхий эдийн хэлбэлзлээс өндөр хамаарч, макро тогтворгүй байдал өндөр байна. Эдийн засгийн өсөлт цар тахлын улмаас 2020 онд 4.4 хувиар агшаад байсан бол 2021 онд ердөө 1.4 хувиар өсөж сэргэсэн бол 2024 онд 5.1 хувьд хүрч өссөн байна. Хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдааны салбарууд агшиж, өсөлтийг сааруулсан байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэрлэсэн дүнгээр 80 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.5 хувиар, бодит дүнгээр 32 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.9 хувиар тус тус өслөө. Нэг хүнд ногдох ДНБ-ийг авч үзвэл 2020 онд 4,128.0 ам доллар байсан 2024 онд 6,898.0 ам доллар буюу 1.7 дахин нэмэгдсэн байна. Манай улсын хувьд эдийн засгийг төрөлжүүлж,</p>		
--	--	--	--	--	--	--

					уул уурхайгаас хамаарал багатай, тогтвортой өсөлттэй бүтэц рүү шилжих шаардлага байна. Иймд боловсруулах үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, санхүү, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон инновацыг дэмжих замаар дотоод нөөц бололцоог өргөжүүлэх бодлогыг "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусган төлөвлөө.		
8	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулна.	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байх, хувиар	Хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тухай бүр зохион байгуулсан.	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. /100 хувь/	Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог 9% бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюуныг ашиглан ил тод байдлыг сайжруулж, үр ашгийг	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				<p>нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа мөн Монгол Улсын хэмжээнд цогц үйлчилгээний төвүүдийг байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар судалгаа хийлээ. Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр дараах сургалтыг зохион байгууллаа. Үүнд: -"Олон хэвт эдийн засаг, суртахууны эдийн засаг" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр яамны албан хаагчдад зохион байгуулав. -"Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийн олон талт хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, тус хэлэлцүүлэгт эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 90 гаруй хүн оролцож, 40 гаруй санал гаргалаа. - Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран "Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийн талаар олон талт хэлэлцүүлгийг 2025 оны 04</p>		
--	--	--	--	--	--	--

					<p>дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, тус хэлэлцүүлэгт хувийн хэвшил, бизнесийн байгууллага болон мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцож, 20 гаруй санал гаргалаа. - "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төслийг боловсруулахдаа нийт 14 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, ШУА-ийн Бага болон Их чуулганаар хэлэлцүүлээ. Олон нийтийн хэлэлцүүлгээс нийт 644 санал гаргаснаас хуульд тогтоомжийн дагуу үндсэн чиглэлийн төсөлд тусгасан. -"Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ыг танилцуулах 2 удаагийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн төлөвлөлтөд оролцож буй албан хаагчдад зохион байгууллаа. Нийт 480 оролцогчид хамрагдсан.</p>		
9	<p>Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгнө.</p>	<p>Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн байх, хувиар</p>	<p>Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн.</p>	<p>Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн байна.</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.14, 9.10.1 дэх заалтад заасны дагуу Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны</p>	<p>7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	100%

				/100 хувь/	<p>төлөвлөгөөнд суурилан тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгаж аймаг, нийслэлийн Засаг даргаас боловсруулсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг батлагдсан аргачлал, зааврын дагуу бодлогын баримт бичгийн уялдааг ханган үр дүнд суурилсан зарчмыг баримтлан боловсруулагдсан эсэхэд санал хүргүүлээ. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг нийслэл, 18 аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд санал, зөвлөмж хүргүүлж мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.</p>		
10	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судална.	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судалсан байх	Хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тухай бүр зохион байгуулсан.	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судалсан байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологийн чиглэлүүдийг тодорхойлох судалгаа хийж, бодлогын хэрэгжилтийн мониторинг, индикатор тооцооллыг	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					автоматжуулах дижитал шийдлийн "AI machine learning" талаар зөвлөх үйлчилгээ авч, гэрээгээр гүйцэтгүүлж байна.		
11	Салбаруудын хөгжлийн бодлогыг орон зайн судалгаанд суурилан тодорхойлох, орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Орон зайн мэдээллийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, хувиар	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн.	Орон зайн мэдээллийн нөхцөл байдлын үнэлгээ хийсэн байна. /100 хувь/	Салбаруудын хөгжлийн бодлогыг орон зайн судалгаанд суурилан тодорхойлох, орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах тухай" 2025 оны 76 дугаар тогтоолын дагуу холбогдох яам, агентлагууд руу 2025 оны 03/974 тоот албан бичгээр "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажлын хэсэг"-т нэр ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн. Тус ажлын хэсгийг байгуулах болон ажлын хэсгийн удирдамжийг боловсруулж байна.	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
12	Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангасан байна.	Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах талаар судалж, бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан байх, хувиар	-	Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах талаар судалж, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан байна. /100 хувь/	Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллав. Өв уламжлалын сангаас "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>индекс"-ийг хууль дээдлэх ёс, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн нийт 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлт ашиглан тооцдог бөгөөд Монгол Улс 2024 онд нийт дүнгээрээ 176 улсаас 60.6 оноотойгоор 76 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна. Шалгуур үзүүлэлтүүдийн онооны ангиллаар өмчийн эрх 92/176 муу, төрийн зарчимт байдал 117/176 муу, бизнесийн эрх чөлөө 79/176 дунд, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал 119/176 бага гэж үнэлэгдсэн байна. Үүнээс үзэхэд хувь хүмүүсийн өмч эзэмших эрх чөлөөг хангах, төрийн албаны авлига авах эрсдэлийг бууруулах, бизнесийн үр ашигтай үйл ажиллагааны хязгаарлалтыг бууруулах, хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах шаардлагатай байгааг харуулж байна. "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д Монгол Улсын өрсөлдөх чадварыг зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, инфляцыг зорилтот интервалд тогтворжуулах, Засгийн газрын өрийг бууруулах, гадаад</p>		
--	--	--	--	--	--	--	--

				худалдааны хэмжээг нэмэгдүүлэх замаар олон улсын өрсөлдөх чадварын индексийг 11 эрэмбээр ахиулж, 50-д хүргэх, өмчлөх эрхийг баталгаажуулах замаар эдийн засгийн эрх чөлөөг сайжруулж, 2024 онд 76-т байгаа эдийн засгийн эрх чөлөөний индексийг 16 байр ахиулж, 2030 он гэхэд 60-д хүргэхээр тусгалаа. Эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах хүрээнд төрийн оролцоо, гааль, татвар, бизнесийн орчин, хөдөө аж ахуй, стандарт зэрэг асуудлуудыг сайжруулна.		
--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр сургалт болон хариуцсан чиглэлийн салбар чиглэлийн хүрээнд хурал,	Эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр сургалт болон хариуцсан чиглэлийн хүрээнд хурал,	-	Эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр сургалт болон хариуцсан чиглэлийн хүрээнд хурал,	“Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тогтвортой хөгжлийн зорилтыг уялдуулах нь”	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

	хэлэлцүүлэгт оролцох	хэлэлцүүлэгт оролцох		хэлэлцүүлэгт оролцсон байна.	олон талт хэлэлцүүлэгт оролцсон.	11-р сар, 12-р сар	
2	Яамны мэдээллийн цагт оролцох	Яамны мэдээллийн цагт оролцох	-	Яамны мэдээллийн цагт оролцсон байна.	Яамны мэдээллийн тогтмол оролцсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ХЯНАСАН:

Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батчулуун Мөнгөнсүм /...../

Огноо:

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, байгаль орчин), Гэрэлмаа Энхболор

/..... Г. Энхболор

Огноо: 2025.12.15



Handwritten mark or signature in the bottom right corner.